



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/009/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан  
Утас: 91119424

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 524

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

**Засаг даргын тамгын газар**

ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөртөө шийдвэр гаргаж илүү цагийн хөлс авсан, нэр бүхий ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлд хамаарахгүй нөхцөлөөр илүү цагийн хөлсийг олгосон, байгууллагын дансанд бүртгэлтэй малыг тоолж, тооцоо бодож баталгаажуулаагүй, Цогт-Өндөр багийн 6 цэцэрлэгт халаалтын тогоо солих төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн боловч ашиглах боломжгүй болсныг баталгаат хугацаанд засварлуулах, дахин авхуулах зэрэг арга хэмжээ аваагүй, шинээр халаалтын тогоог дахин худалдан авч төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, Төрийн захиргааны албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр томилохдоо төрийн үйлчилгээний цалингийн ангиллаар цалинжуулах тушаал гаргаж нэмэгдэл, урамшуулал илүү олгосон, төрийн албаны нөөцөд бүртгэлгүй иргэнийг төрийн захиргааны албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр томилж цалин олгосон, төрийн албаны сул орон тоо гарсан даруйд олон нийтэд мэдээлээгүй, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд захиалгыг хүргүүлээгүй, ЗДТГ-ын газарт бүртгэлтэй хөрөнгийг түрээсэлж гэрээний дагуу төлбөрөө төлөөгүй иргэдийн авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

## **Иргэдийн төлөөлөгчдийн хурал**

Хөдөлмөрийн тухай хуульд заасан илүү цагаар ажиллуулах шалгуурт нийцэхгүй үндэслэлээр илүү цагийн хөлсийг олгосон, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зардлаас цагдаагийн байгууллагын спортын тэмцээний бооцоонд 1,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардлаас олон нийтийн цагдаагийн урамшуулалд 131,328.9 мянган төгрөг, “Хурал цом” спортын наадам, уралдаан тэмцээнд оролцох зардалд 2,138.5 төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал, урамшлын зардлаас байгууллагад хамааралгүй этгээдэд тэмцээн, уралдааны шагнал, тэтгэмж, материал худалдан авсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хуралдаан, хамтарсан багийн уулзалтын хоолны төлбөрт зориулан төсвийг арвилан хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулсан.

## **Өндөрхаан хот тохижилт**

Анхан шатны баримтгүйгээр шатахуун зарцуулсан, ОНӨААТҮГ-ын ажилчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдэл олгосон, ажилчдын цалингаас хамтын сан, үйлдвэрчний эвлэл нэрээр суутгаж, хувь хүний харилцах дансанд шилжүүлсэн.

## **Тахилгат тосгоны ЗАА**

Үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй фургон авто машиныг Хэрлэн сумын Засаг даргын тамгын газарт Орон нутгийн өмчийн газрын шийдвэргүй, ашиглалтын гэрээ байгуулаагүй ашиглуулсан, бараа материалын түлш, шатах тослох материалын үлдэгдлийг жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор тоолоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй, Захирагчийн ажлын албаны хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтний орон тоонд төрийн албаны нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилон ажиллуулж цалин олгосон. Эдгээр зөрчлүүд нь дор дурьдсан хууль, тогтоомжийг зөрчсөн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 “төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5.”батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,” 26.1-т “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.“Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4-т “Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагчаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д “байгууллагын төсвөөр

биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах"-ыг хориглоно, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна" 46.5.8 "олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх;" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралт "ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд Төрийн албаны хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн актын дагуу Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр, нийтлэг баталгаа, нэмэгдэл баталгаатай холбоотой ажил олгогчоор дамжуулан олгох нэг удаагийн тэтгэмж, дэмжлэг энд хамаарна", Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйл."Цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах", 119.1."Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно", ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, ЗГ-ын 2024 оны 82 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 1.1. "Төрийн албан хаагчдыг орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгоход энэ журмыг баримтална" гэснийг зөрчсөн нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Хэрлэн сум 2025 онд 12,008,080.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 13,981,038.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 1,972,958.3 мянган төгрөгөөр буюу 116.4 хувиар биелүүлж, аймгийн төсөвт 4,354,323.3 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Татварын орлогыг нэр төрлөөр авч үзвэл үл хөдлөх хөрөнгийн албан татвар, газрын төлбөрийн орлогууд тасарсан байна.

### **Аудитын гол асуудал**

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 446,955.3 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 98,010.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 348,944.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлэв.

### **Бусад асуудлын хэсэг**

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2025 оны 12 дугаар сарын 16-ны хуралдааны 2 дугаар тогтоолоор сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 91.4 хувь, "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар 2,766,641.7 мянган төгрөгийн 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1,069,427.0 мянган төгрөгөөр 16 арга хэмжээг хэрэгжүүлж, 440,000.0 мянган төгрөгийн 3 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Цаашид төсвийн төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг нэр төрлөөр нь биелүүлэх, батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		6,543,958.08	5,770,736.40
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	4,616,712.03	3,257,976.44
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,366,010.71	1,682,857.82
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	180.00	180.00
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	529,555.34	781,922.14
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	31,500.00	47,800.00
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		48,659,585.17	52,794,774.87
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	48,659,585.17	52,794,774.87
9	1.2.2.02 Биет хөрөнгө		42,062,508.64	46,197,698.34
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	6,597,076.53	6,597,076.53
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		55,203,543.25	58,565,511.28
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.0	70,436.07
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.0	70,436.07
14	2.1.1.03 Өглөг		0.0	70,436.07
15	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		55,203,543.25	58,495,075.21
16	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		55,203,543.25	58,495,075.21
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		6,719,118.55	6,719,118.55
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		45,118,070.62	48,409,602.57
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		3,366,354.09	3,366,354.09
20	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		55,203,543.25	58,565,511.28

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		23,956,861.95	21,992,122.81
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		12,340,419.45	13,031,409.10
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		11,232,181.17	11,988,880.31
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		11,232,181.17	11,988,880.31
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		450,568.49	315,768.28
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		657,669.78	726,760.51
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	10,116,448.02	8,960,713.71
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	149,351.03
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,499,994.48	0.0
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	13,444,936.56	18,488,683.35
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		13,444,936.56	18,488,683.35
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		12,118,280.46	13,940,249.01
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,593,708.14	2,033,375.55
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		196,466.4	252,261.83
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,505,452.71	3,642,177.68
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		95,795.97	208,364.33
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		9,954.10	682.60
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		282,709.96	274,407.61
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		11,791.00	23,790.00
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,519,684.70	3,250,224.53
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		3,902,717.46	4,254,964.88
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,326,656.10	4,548,434.34
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		10,511,925.39	3,503,439.46
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,287,088.85	212,151.52
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-2,287,088.85	-212,151.52
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		8,224,836.55	3,291,287.94

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,977,991.86		46,977,991.86
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	714.85		714.85
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	46,978,706.71		46,978,706.71
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	8,224,836.55		8,224,836.55
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	55,203,543.25		55,203,543.25
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	55,203,543.25		55,203,543.25
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	244.01		244.01
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	55,203,787.26		55,203,787.26
9	1.7 Тайлант үеийн үр дүн	3,291,287.94		3,291,287.94
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	58,495,075.21		58,495,075.21

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (Мянган төгрөгөөр)

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	14,816,480.82	15,311,437.13
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	12,340,419.45	13,031,409.1
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	11,232,181.17	11,988,880.31
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	450,568.49	315,768.28
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	657,669.78	726,760.51
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	558,930.51	620,832.95
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	98,729.45	62,863.76
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	9.82	43,063.80
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	932,771.64	2,280,028.03
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	932,771.64	1,025,953.73
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	172,280.80
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	1,081,793.50
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,543,289.74	0.0
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,955,445.61	14,576,363.47
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	9,955,445.61	14,576,363.47
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,579,535.38	10,020,027.32
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,593,708.14	2,021,955.09
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	196,235.68	252,261.83
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,509,052.71	3,651,988.27
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	99,901.11	102,805.72
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	15,820.10	5,079.20
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	313,285.23	314,105.61
23	1.1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	11,791.00	23,790.00
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,497,742.05	3,378,870.73
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	341,999.36	269,170.86
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,375,910.23	4,556,336.15
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,861,035.22	735,073.66
28	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,390,616.10	1,673,809.26
29	1.1.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,390,616.10	1,673,809.26
30	1.1.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	2,390,616.10	1,673,809.26
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,390,616.10	-1,673,809.26
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000.00	420,000.00
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-150,000.00	-420,000.00
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,320,419.12	-1,358,735.60
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,296,292.91	4,616,712.03
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,616,712.03	3,257,976.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	16,743,603.7	15,229,166.66
2	3.1.01.1.1 Татварын орлого	11,438,080	13,129,419.44
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	10,400,000	12,074,959.31
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	10,400,000	12,074,959.31
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	9,130,000	10,222,443.14
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	300,000	639,639.12
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	750,000	873,573.31
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	220,000	339,303.73
9	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	350,930	322,094.42
10	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	347,000	282,390.17
11	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	3,930	5,075
12	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	0.0	34,629.25
13	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	687,150	732,365.71
14	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	563,000	621,504.95
15	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	18,000	34,425.53
16	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5,000	16,959.12
17	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	540,000	570,120.3
18	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	123,500	67,796.96
19	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	123,500	67,796.96
20	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	650	43,063.8
21	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	650	43,063.8
22	3.1.01.1.2 Татварын бус орлого	5,305,523.7	2,099,747.23
23	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	845,000	1,017,953.73
24	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	550,000	706,062.01
25	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	275,000	145,116.99
26	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	0.0	21,217.86
27	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	20,000	145,556.87
28	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	3,378,730.2	0
29	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	3,378,730.2	0
30	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,081,793.5	1,081,793.5
31	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,081,793.5	1,081,793.5
32	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,356,793.5	20,520,977.52
33	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	-1,122,542.8	18,603,143.03
34	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,864,561.8	10,033,467.78
35	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,131,600.7	2,021,955.09
36	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	1,046,663.3	911,457.2
37	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	396,497.8	612,342.55

**Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

38	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	159,540	150,803.5
39	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	160,346.4	77,879.37
40	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	368,553.2	269,472.47
41	3.1.01.2.1.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	266,948.3	252,261.83
42	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	180,842.7	173,080.95
43	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	21,326.5	20,322.96
44	3.1.01.2.1.1.2.03 YOMШӨ-ний даатгал	11,463.2	11,429.96
45	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	10,663.2	9,436.58
46	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	42,652.7	37,991.37
47	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,129,458.1	3,649,885.05
48	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	575,836	411,503.82
49	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	2,934,264.3	2,914,939.11
50	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	619,357.8	323,442.11
51	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	123,312.7	84,677.32
52	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	19,232.4	12,932.4
53	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	65,166.8	50,617.13
54	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,960	12,336.14
55	3.1.01.2.1.1.4.04 Ном, хэвлэл	15,600	510
56	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,565.3	1,744
57	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,788.2	6,537.65
58	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	8,350	5,079.2
59	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,350	5,079.2
60	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	365,729.5	325,474.4
61	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	79,655.2	70,529.86
62	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,483.1	504
63	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	284,591.2	254,440.54
64	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	29,629	23,790
65	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	29,629	23,790
66	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,461,843.4	3,385,215.58
67	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,438,485.5	3,379,046.79
68	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,287.3	0.0
69	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	3,050	0.0
70	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	2,350.6	1,430.4
71	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	520	92
72	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,600	2,980
73	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	10,550	1,666.39
74	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	347,690.1	285,129.31
75	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	306,740.3	254,534.35
76	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,949.8	30,594.96
77	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-11,987,104.6	8,569,675.25
78	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-12,153,515.5	8,414,323.3
79	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,383,323.3	4,383,323.3

**Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

80	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-16,536,838.8	4,031,000
81	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	166,410.9	155,351.95
82	3.1.01.2.1.4.2.06 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	121,827.9	116,319.54
83	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,583	39,032.41
84	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,899,866.3	1,497,834.49
85	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	1,899,866.3	1,497,834.49
86	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	579,470	420,000
87	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	579,470	420,000
88	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	15,386,810.2	-5,291,810.86
89	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-15,386,810.2	5,291,810.86
90	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-15,386,810.2	5,291,810.86
91	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	4,616,705.03
92	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	3,355,894.17
93	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	80	69
94	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	1
95	6.1.01 Төсвийн байгууллага	2	1
96	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	34
97	6.2.01 Удирдах ажилтан	8	7
98	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	20	18
99	6.2.03 Үйлчлэх ажилтан	2	0.0
100	6.2.04 Гэрээт ажилтан	9	9
101	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39	34
102	6.5.01 Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	17	13
103	6.5.09 Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14	14
104	6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ)	8	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	192,304.80
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	192,304.80
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	192,304.80
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	192,304.80
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	192,304.80
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,132.10
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	97,172.70
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	178,570.05
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	178,570.05
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	174,643.90
2103	1.1.1.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,103.22
210301	1.1.1.2.1.1.3.1 Гэрэл, цахилгаан	1,178.22
210302	1.1.1.2.1.1.3.2 Түлш, халаалт	925.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	18,128.40
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	3,969.98
210403	1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,827.18
210406	1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,331.25
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	46,564.68
210601	1.1.1.2.1.1.6.1 Багаж, техник, хэрэгсэл	9,154.78
210604	1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар	37,409.90
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,406.45
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,406.45
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	6,441.15
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	6,441.15
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,926.15
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	3,926.15
213209	1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,926.15
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	13,734.75
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(13,734.75)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(13,734.75)

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 5 байгууллага, 1 ОНӨААТҮГ, 1 төрийн сан, 2 тусгай сан, улсын төсвийн 16 байгууллагын тогтмол зардал нийт 25 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 15 байгууллагад санал дүгнэлт гаргаж 10 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэлээ.

Аудитад хамрагдсан Засаг даргын тамгын газар, Тахилгат тосгоны ЗАА, Өндөрхаан хот тохижилт ОНӨҮГ-т аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж “Хязгаарлалттай”, 1, 2, 4 дүгээр сургуулиуд “Өөрчлөлтгүй”, 1, 2 дугаар цэцэрлэгүүдэд “Ари фاینэнс аудит” ХХК аудитыг хийж “Өөрчлөлтгүй”, 5, 7, 8, 9, 10 дугаар цэцэрлэгүүдэд “Платиниум прогресс аудит” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт гаргасан байна. Хэрлэн сумын ИТХ, Соёлын төв, Тахилгат тосгоны ЭМТ, Хоршоог хөгжүүлэх сан, ОНХС, 1, 5 дугаар сургууль, 3, 4, 6 дугаар цэцэрлэгүүдэд санхүүгийн тайлангийн үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн байна.

### 5.1 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар

#### Орон нутгийн төсвийн байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,295,505.1 мянган төгрөгийн 28 алдаа, зөрчил илэрснээс 71,331.0 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 6,948.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 5,217,225.2 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 19 албан шаардлага хүргүүлж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах 2 зөвлөмж өгсөн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

#### **Засаг даргын тамгын газар:**

- ✓ ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөртөө шийдвэр гаргаж 2,066.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс авсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ✓ Шатах тослох материалын тайланг гаргаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт болон хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүйгээр ЗДТГ-ын даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/41 тушаалаар 55,767.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Нэр бүхий ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлд хамаарахгүй нөхцөлөөр 18,696.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Байгууллагын дансанд бүртгэлтэй 6,521.7 мянган төгрөгийн малыг тоолж, тооцоо бодож баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Цогт-Өндөр багийн 6 цэцэрлэгт 17,869.9 мянган төгрөгийн халаалтын тогоо солих төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж 2025 оны 5-р сард ЗДТГ хүлээн авсан боловч халаалтын тогоо цоорч ашиглах боломжгүй болсон байна. Үүнтэй холбоотойгоор нийлүүлэгчийн баталгаат хугацаанд хариуцах үүргийг нэхэмжлэлгүйгээр шинэ халаалтын тогоо нэмж худалдан авсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Нэр бүхий 10 хүнийг Төрийн захиргааны албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр томилохдоо төрийн үйлчилгээний цалингийн ангиллаар цалинжуулах тушаал гаргаж нэмэгдэл, урамшуулал олгосноор 25,739.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан, Төрийн албаны нөөцөд бүртгэлгүй иргэнийг төрийн захиргааны албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр томилж 8,515.5 мянган төгрөгийн цалин олгосон,

- Төрийн албаны сул орон тоо гарсан дарууд олон нийтэд мэдээлээгүй, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд захиалгыг хүргүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ ЗДТГ-ын газарт бүртгэлтэй хөрөнгийг түрээсэлж гэрээний дагуу төлбөрөө төлөөгүй 38 иргэний 27,426.3 мянган төгрөгийн авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
  - ✓ ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид нэмэгдэл цалин, үр дүнгийн урамшуулалд 38,851.6 мянган төгрөгийг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
  - ✓ Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг байршуулах хэсэгт 391,218.2 мянган төгрөгийн 22 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 3,554,286.0 мянган төгрөгийн 65 мэдээлэл, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 10,908.8 мянган төгрөгийн 1, нийт 3,956,413.0 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
  - ✓ Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 55 нэр төрлийн 109 ширхэг хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлээгүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

#### **Иргэдийн төлөөлөгчдийн хурал:**

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль заасан илүү цагаар ажиллуулах шалгуурт нийцэхгүй үндэслэлээр нэр бүхий 5 албан хаагчид 1,942.0 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ✓ Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зардлаас цагдаагийн байгууллагын спортын тэмцээний бооцоонд 1,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардлаас олон нийтийн цагдаагийн урамшуулалд 131,328.9 мянган төгрөг, “Хурал цом” спортын наадам, уралдаан тэмцээнд оролцох зардалд 2,138.5 төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал, урамшлын зардлаас байгууллагад хамааралгүй этгээдэд тэмцээн, уралдааны шагнал, тэтгэмж, материал худалдан авах зэрэгт 11,843.8 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хуралдаан, хамтарсан багийн уулзалтын хоолны төлбөрт 3,297.0 мянган төгрөг нийт 149,608.2 мянган төгрөгийг арвилан хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

#### **Өндөрхаан хот тохижилтын газар:**

- ✓ Анхан шатны баримтгүйгээр 2,940.3 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ✓ ОНӨААТҮГ-ын ажилчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдэлд 221,950.2 мянган төгрөгийг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Ажилчдын цалингаас 11,067.1 мянган төгрөгийг хамтын сан, үйлдвэрчний эвлэл нэрээр суутгаж, хувь хүний харилцах дансанд шилжүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Тендер зарлалгүйгээр 101,403.2 мянган төгрөгийн камер засварын үйлчилгээ, цахилгаан автобусны зай хураагуур, цас хайлуулах бодис зэргийг худалдан авсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Жилийн эцэст 54,118.5 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, сэлбэг хэрэгслийг худалдан авч нөөцөлсөн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах эд хөрөнгийн жагсаалтыг эрх бүхий этгээдээр батлуулалгүйгээр худалдан авсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

- ✓ Шилэн дансны нэгдсэн системд Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягтай холбоотой 566,607.7 мянган төгрөгийн 24 мэдээллийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Тус газар нь улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ статустай боловч, байгууллагын дүрэм, санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэр нь төсөвт газрын хэлбэрээр ажиллаж байгаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.
- ✓ Баланс дээрх үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нь тодруулга тайлгаас 31,821.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг санхүүгийн тайланд залруулсан.

#### **Тахилгад тосгоны Захирагчийн ажлын алба:**

- ✓ Бараа материалын тайлангийн сэлбэг хэрэгсэл дансны 360.0 мянган төгрөгийн зарлагыг үндсэн цалингийн зарлагын дансаар зарлагдаж, цалингийн зардлыг зөрүүлснийг санхүүгийн тайланд залруулсан.
- ✓ Үндсэн хөрөнгийн тодруулгын болон дэлгэрэнгүй тайлангаарх хуримтлагдсан элэгдэл, тайлант оны элэгдлийн зардлыг 4,311.3 мянган зөрүүтэй бүртгэснийг санхүүгийн тайланд залруулсан.
- ✓ Үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 37,900.0 мянган төгрөгийн фургон авто машиныг Хэрлэн сумын Засаг даргын тамгын газарт Орон нутгийн өмчийн газрын шийдвэргүй, ашиглалтын гэрээ байгуулаагүй ашиглуулж байгаа зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Бараа материалын түлш, шатах тослох материалын 3,600.0 мянган төгрөгийн нүүрс, 342.2 мянган төгрөгийн түлшний үлдэгдлийг жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор тоолоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Захирагчийн ажлын албаны хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтний орон тоонд төрийн албаны нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилон ажиллуулж 4,799.1 мянган төгрөгийг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

#### **Хоршоо хөгжүүлэх сан:**

- ✓ Сангийн зээлийн хүүгийн авлага 34,838.2 мянган төгрөгийг зээлийг авлагаас салгаж бүртгээгүй алдааг санхүүгийн тайланд залруулсан.

#### **Улсын төсвийн байгууллагуудад гарсан алдаа зөрчил.**

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 463,444.8 мянган төгрөгийн 29 алдаа, зөрчил илэрснээс 178,877.1 мянган төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 4,506.6 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 280,061.1 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 10 албан шаардлага хүргүүлж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах 1 зөвлөмж өгсөн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

*Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:*

#### **Тахилгат тосгоны ЭМТ:**

- ✓ ЭМТ-ийн 49,245.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодож баталгаажуулаагүй, анхан шатны баримтын шаардлагыг хангахгүй байгаа зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Санхүүгийн тайланд 22,685.7 мянган төгрөгийг элэгдлийг дутуу тусгасныг залруулж тайланд тусгуулж залруулав.

### 1-р сургууль:

- ✓ Тайлант онд 3 ажилтанд ээлжийн амралтын хугацаанд 1,307.3 мянган төгрөгийн цалинг давхардуулан тооцон олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ✓ Дотоод хяналтын 2 ажилтан, мужаан, хүний нөөц хариуцсан 2 ажилтанд сар бүр 40 хувиар тооцон 12,152.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 2-р сургууль:

- ✓ Жирэмсэн, амаржсан, хүүхдээ асарч байгаа эхчүүд, тэтгэвэр тогтоолгон ажиллагч, гэрээт ажилтнуудын даатгуулагчийн төрлийн кодыг хүний нөөцийн болон НДШ-ийн программд буруу оруулснаас даатгуулагч, ажил олгогчийн төлөх шимтгэлийг 1,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэж, 1,835.8 мянган төгрөгийн цалинг НДШ-ийн тайланд илүү тайлагнасан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Шилэн дансны нэгдсэн системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 48,100.0 мянган төгрөгийн 2 орлогын гүйлгээ, 12,100.0 мянган төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 113,100.0 мянган төгрөгийн 8 худалдан авалтыг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Цалингаас суутгасан татварыг 845.0 мянган төгрөгөөр илүү төлж, авлагаар бүртгэлгүй зардалд хаасан алдааг санхүүгийн тайланд залруулсан.
- ✓ Үндсэн хөрөнгийн тодруулгын тайлан, дэлгэрэнгүй тайлангаарх хуримтлагдсан элэгдлийн дүн, тайлант оны элэгдлийн зардал 9,827.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг санхүүгийн тайланд залруулсан.

### 3-р сургууль:

- ✓ Цалингийн зардлаас 18 ажилтанд үндэслэлгүй 15,651.2 мянган төгрөгийн нэмэгдэл цалин, дотоод хяналтын 2 ажилтанд сар бүр 30 хувиар, хүний нөөц, дотоод хяналт хариуцсан 1 ажилтанд сар бүр 70 хувиар тооцон 18,907.3 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгож, нийт 34,558.5 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 4-р сургууль:

- ✓ Багш ажилчдын болон хүүхэд хамгааллын сургалтын төлбөрт 5,240.0 мянган төгрөгийг гэрээний дагуу урьдчилж шилжүүлснийг авлагаар тусгаагүй алдааг санхүүгийн тайланд залруулсан.

### 5-р сургууль:

- ✓ Аудитаар 1,420.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалд бүртгэсэн алдааг санхүүгийн тайланд залруулсан.

### 1-р цэцэрлэг:

- ✓ Ур чадварын нэмэгдлийг хагас жил тутамд шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, аль түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 8 ажилтанд 10-25 хувиар, цэцэрлэгийн эрхлэгчид 20 хувиар тус тус тооцож 3,414.5 мянган төгрөгийг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Бичиг хэргийн 3,186.7 мянган төгрөгийн 32 нэр төрлийн материалыг аж ахуйн бараа материалын дансанд бүртгэсэн алдааг санхүүгийн тайланд залруулсан.
- ✓ Мөнгөн хөрөнгийн гүйлгээ болон үлдэгдлийг банкны дансны үлдэгдлийн баталгаатай тулган шалгахад эдийн засгийн ангиллыг буруу сонгосноос улсын төсвийн харилцах дансны гүйлгээг 20,138.7 мянган төгрөгийг зөрүүтэй бүртгэснийг санхүүгийн тайланд залруулсан.

## 2-р цэцэрлэг:

- ✓ Ур чадварын нэмэгдлийг хагас жил дутам тутамд шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, аль түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 5 ажилтанд 20-25 хувиар, цэцэрлэгийн эрхлэгчид 20 хувиар тус тус тооцож 2,834.2 мянган төгрөгийг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7 нэр төрлийн (анхны өртөг 5,498.5 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.
- ✓ Аудитаар 226.5 мянган төгрөгийн 11 нэр төрлийн аж ахуйн бараа материалыг бичиг хэргийн материалын дансанд бүртгэснийг залруулсан.

## 4-р цэцэрлэг:

- ✓ Үлдэх өртгөө бүрэн нөхөж элэгдлийн хугацаа дууссан боловч ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг шинэчлэн үнэ тогтоож бүртгэхдээ дахин үнэлгээний дансыг нэмэгдүүлж нягтлан бодох бүртгэлийг 20,018.4 мянган төгрөгөөр алдаатай хөтөлснийг санхүүгийн тайланд залруулсан.

## 5-р цэцэрлэг:

- ✓ Тайлант онд 1 ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон орон нутгийн нэмэгдэлд 2,120.4 мянган төгрөгийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ✓ Тайлант онд 10,060.0 мянган төгрөгийн газрыг хөрөнгөөр бүртгэж авахдаа үнэ төлбөргүй орлогоор бүртгэснийг санхүүгийн тайланд залруулсан.

## 6-р цэцэрлэг:

- ✓ Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайлан, дэлгэрэнгүй журналаас 2,470.1 зөрүүтэй илэрхийлснийг санхүүгийн тайланд залруулав.
- ✓ Үлдэх өртгөө бүрэн нөхөж элэгдлийн хугацаа дууссан боловч ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг шинэчлэн үнэ тогтоож бүртгэхдээ дахин үнэлгээний дансыг нэмэгдүүлж нягтлан бодох бүртгэлийг алдаатай хөтөлсөн

## 7-р цэцэрлэг:

- ✓ Тайлант онд 3 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 474.2 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

## 8-р цэцэрлэг:

- ✓ Байгууллагын эрхлэгчийн 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн Б/06 тушаалаар 2 ажилтанд нийт 393.5 мянган төгрөгийн шилдэг ажилтны шагналыг зардлын ангилал зөрчиж, цалингийн зардлаас олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

## 9-р цэцэрлэг:

- ✓ Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас 749.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

## 10-р цэцэрлэг:

- ✓ Тайлант онд 2 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 211.4 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- ✓ Орон нутгийн өмчийн газраас үнэлгээ хийгдсэн 2,000 мкв 76.050.0 мянган төгрөгийн газрыг шилжүүлэн авахдаа "үнэ төлбөргүй хөрөнгө" дансанд бүртгэснийг санхүүгийн тайланд залруулсан.

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 446,955.3 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 98,010.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 348,944.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлэв.

### Залруулсан алдаа

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой:

- ✓ Татварын 98,010.3 мянган төгрөгийн замд яваа орлогыг санхүүгийн тайланд тусгаагүйг залруулсан.

### Зөрчил

Санхүүгийн тайлангийн аудитаар 348,944.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

#### 5.1 ТӨЛБӨРИЙН АКТ

Байхгүй.

#### 5.2 АЛБАН ШААРДЛАГА

Байхгүй

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

- ✓ Сумын ИТХ-аар баталсан Хоршоо хөгжүүлэх сангийн орлого 145,117.0 мянган төгрөг, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 64.609.8 мянган төгрөг, Газрын төлбөрийн орлого 55.703.0 мянган төгрөг, нийт 265,429.9 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөг биелээгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

- ✓ Татварын орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр биелүүлэх арга хэмжээ авч ажиллах.

2. Санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн өмнөх оны үлдэгдлийн 83,500.0 мянган төгрөгийг дутуу төлөвлөсөн байна.

#### Өгсөн зөвлөмж:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг үндэслэлтэй бүрэн төлөвлөх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгалгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Тахилгат ЗАА	2	4,671.3			2	4,671.3	2	4,671.3		
Хот тохижилт ХХС	1	31,821.5			1	31,821.5	1	31,821.5		
	1	34,838.2			1	34,838.2	1	34,838.2		
<b>ОН-ын байгууллагын дүн</b>	<b>4</b>	<b>71,331.0</b>			<b>4</b>	<b>71,331.0</b>	<b>4</b>	<b>71,331.0</b>		
Тахилгат ЭМТ	1	22,685.7	1	22,685.7			1	22,685.7		
10-р цэцэрлэг	1	76,050.0			1	76,050.0	1	76,050.0		
4-р цэцэрлэг	1	20,018.4			1	20,018.4	1	20,018.4		
6-р цэцэрлэг	2	9,178.8			2	9,178.8	2	9,178.8		
1-р цэцэрлэг	2	23,325.5			2	23,325.5	2	23,325.5		
5-р цэцэрлэг	1	10,060.0			1	10,060.0	1	10,060.0		
2-р цэцэрлэг	1	226.5			1	226.5	1	226.5		
2-р сургууль	2	10,672.2			2	10,672.2	2	10,672.2		
4-р сургууль	1	5,240.0			1	5,240.0	1	5,240.0		
5-р сургууль	1	1,420.0			1	1,420.0	1	1,420.0		
<b>УТ-ын байгууллагын дүн</b>	<b>13</b>	<b>178,877.1</b>	<b>1</b>	<b>22,685.7</b>	<b>12</b>	<b>156,191.4</b>	<b>13</b>	<b>178,877.1</b>		
ТТЗ	1	98,010.3	1	98,010.3			1	98,010.3		
<b>Дүн</b>	<b>18</b>	<b>348,218.4</b>	<b>2</b>	<b>120,696.0</b>	<b>16</b>	<b>227,522.4</b>	<b>18</b>	<b>348,218.4</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	10	111,432.7	1	2,066.6	8	109,366.1	1	0
ИТХ	2	151,550.2	1	1,942.0	1	149,608.2	-	-
Тахилгат ЗАА	2	41,842.2	-	-	2	41,842.2	-	-
Хот тохижилт	4	236,007.6	1	2,940.3	2	233,067.3	1	-
<b>ОН-ын байгууллагын дүн</b>	<b>18</b>	<b>540,832.7</b>	<b>3</b>	<b>6,948.9</b>	<b>13</b>	<b>533,883.8</b>	<b>2</b>	<b>-</b>
Тахилгат ЭМТ	1	49,245.8	-	-	1	49,245.8	-	-
1-р цэцэрлэг	2	3,414.5	-	-	2	3,414.5	-	-
2-р цэцэрлэг	3	2,834.2	-	-	2	2,834.2	1	-
5-р цэцэрлэг	1	2,120.2	1	2,120.2	-	-	-	-
7-р сургууль	1	474.2	1	474.2	-	-	-	-
1-р сургууль	1	393.5	1	393.5	-	-	-	-
9-р цэцэрлэг	1	749.9	-	-	1	749.9	-	-
10-р цэцэрлэг	1	211.4	1	211.4	-	-	-	-
1-р сургууль	2	13,459.3	1	1,307.3	1	12,152.0	-	-
2-р сургууль	1	2,835.8			1	2,835.8		
Тахилгат ЭМТ	1	34,558.5			1	34,558.5		
<b>УТ-ын байгууллагын дүн</b>	<b>15</b>	<b>110,297.3</b>	<b>5</b>	<b>4,506.6</b>	<b>9</b>	<b>105,790.7</b>	<b>1</b>	<b>-</b>
ТТЗ	2	348,944.9					2	348,944.9
<b>Дүн</b>	<b>35</b>	<b>1,000,074.9</b>	<b>8</b>	<b>11,455.5</b>	<b>22</b>	<b>639,674.5</b>	<b>5</b>	<b>348,944.9</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Хот тохижилт	1	566,607.7			1	566,607.7	-	-
ЗДТГ	1	3,956,413.0			1	3,956,413.0		

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ОН-ын байгууллагын дүн	2	4,523,020.7			2	4,523,020.7		
2-р сургууль	1	174,270.4			1	174,270.4		
УТ-ын байгууллагын дүн	1	174,270.4			1	174,270.4		
Шилэн дансны нийт дүн	3	4,697,291.1			3	4,697,291.1		
<b>Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Хот тохижилт	3	155,521.7			3	155,521.7		
Тахилгат ЗАА	1	4,799.1			1	4,799.1		
ОН-ийн байгууллагын дүн	4	160,320.8			4	160,320.8		
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>4,857,611.9</b>			<b>7</b>	<b>4,857,611.9</b>		